



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

598.	Буганы Вант Улстай дипломат харилцаа тогтоох тухай	Дугаар 38	2274
599.	Бүгд Найрамдах Панам Улстай дипломат харилцаа тогтоох тухай	Дугаар 39	2274
600.	Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 40	2274
601.	Сонгуулийн ерөнхий хорооны даргыг томилох тухай	Дугаар 41	2275
602.	Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргыг томилох тухай	Дугаар 42	2275
603.	Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох тухай	Дугаар 43	2276
604.	Монголбанкны Дэд ерөнхийлөгчийг томилох тухай	Дугаар 44	2276

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

605.	Аймаг, нийслэлийн Засаг даргын харьяа зарим агентлагийн тухай	Дугаар 32	2277
606.	Хүүхдийн мөнгө олгох ажлыг зохион байгуулах тухай	Дугаар 49	2278
607.	Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам батлах тухай	Дугаар 70	2279



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 10 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 38

Улаанбаатар  
хот

### **Бутаны Вант Улстай дипломат харилцаа тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бутаны Вант Улстай дипломат харилцаа тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 10 дугаар  
сарын 04-ний өдөр

Дугаар 39

Улаанбаатар  
хот

### **Бүгд Найрамдах Панам Улстай дипломат харилцаа тогтоох тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Бүгд Найрамдах Панам Улстай дипломат харилцаа тогтоосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 10 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар  
хот

### **Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай**

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Намсрайжавын Лувсанжавыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Сонгуулийн ерөнхий хорооны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2012 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 10 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар  
хот

**Сонгуулийн ерөнхий хорооны  
даргыг томилох тухай**

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Чойнзонгийн Содномцэрэнг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны даргаар томилсугай.

2.Сонгуулийн ерөнхий хорооны даргаар томилогдсон тул Чойнзонгийн Содномцэрэнг Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2012 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 10 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар  
хот

**Сонгуулийн ерөнхий хорооны нарийн  
бичгийн даргыг томилох тухай**

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн



тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Батнямын Алтанжаргалыг Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн даргаар томилсугай

2.Энэ тогтоолыг 2012 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 10 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар  
хот

**Сонгуулийн ерөнхий хорооны  
гишүүнээр томилох тухай**

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Даваадоржийн Дэлгэрцогтыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2012 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 10 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар  
хот

**Монголбанкны Дэд ерөнхийлөгчийг  
томилох тухай**

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Монголбанкны Дэд ерөнхийлөгчөөр Энхбаярын Батшугарыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2012 оны 10 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2012 оны 9 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар  
хот

### **Аймаг, нийслэлийн Засаг даргын харьяа зарим агентлагийн тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөж, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг шинээр болон өөрчлөн байгуулагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийг “Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс” гэж, Хүүхдийн төлөө хэлтсийг “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс” гэж, Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Халамжийн үйлчилгээний газрыг “Нийгмийн халамж, үйлчилгээний газар” гэж, Хүүхдийн төлөө газрыг “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар”, Нийслэлийн дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийг “Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Аймаг, нийслэл, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний газар, хэлтэс болон Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, хэлтсийг зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд, газар, хэлтсийн үйл ажиллагааг шуурхай удирдлага, ажиллах нөхцөлөөр хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 67 дугаар тогтоолын



4 дүгээр зүйлийн “-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс;” гэснийг “-Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс;” гэж, “-Хүүхдийн төлөө хэлтэс;” гэснийг “-Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс;” гэж, “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах тухай” Засгийн газрын 2008 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 68 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн “22. Халамжийн үйлчилгээний газар” гэснийг “22. Нийгмийн халамж, үйлчилгээний газар” гэж, “25. Хүүхдийн төлөө газар” гэснийг “25. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД**

**С.ЭРДЭНЭ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2012 оны 9 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
хот

### **Хүүхдийн мөнгө олгох ажлыг зохион байгуулах тухай**

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17.1.3, Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 4.2, Улсын Их Хурлын 2012 оны 31 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүний хөгжил сангаас Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт 2012 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүүхдийн мөнгө олгох болсонтой холбогдуулан 10 дугаар сарын сүүлийн арав хоногт багтаан хүүхдийн мөнгө олгохоор бэлтгэл ажлыг зохион байгуулахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд даалгасугай.

2. Хүүхдийн мөнгийг 2012 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгоход шаардагдах хөрөнгийг тухай бүрт нь санхүүжүүлэх болон хүүхдийн мөнгө олгох ажлыг улсын хэмжээнд зохион байгуулахтай холбогдуулан маягт хэвлэх, сургалт, сурталчилгаа хийх, программ хангамж боловсруулах зардалд зориулан 154.8 (нэг зуун тавин дөрвөн сая найман зуун мянган) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргах арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.



3. Хүний хөгжил сангаас хүүхдийн мөнгө олгосон ажлын дүнг 2013 оны 1 дүгээр сарын 25-ны дотор Засгийн газарт танилцуулахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**САНГИЙН САЙД**

**Ч.УЛААН**

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД**

**С.ЭРДЭНЭ**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2012 оны 9 дүгээр  
сарын 29-ны өдөр

Дугаар 70

Улаанбаатар  
хот

### **Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам батлах тухай**

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 17.1.3, Хүний хөгжил сангийн 2012 оны төсвийн тухай хууль, Улсын Их Хурлын 2012 оны 31 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хүний хөгжил сангаас хүүхдэд мөнгө олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт хүүхдийн мөнгө олгох ажлыг энэ тогтоолын 1 дүгээр зүйлээр баталсан журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД**

**С.ЭРДЭНЭ**

Засгийн газрын 2012 оны 70 дугаар  
тогтоолын хавсралт

## **ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГААС ХҮҮХДЭД МӨНГӨ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. 0-18 хүртэлх насны хүүхдэд Хүний хөгжил сангаас бэлэн мөнгө (цаашид “хүүхдийн мөнгө” гэх) олгохтой холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.



1.2. Хүүхдийн мөнгийг Монгол Улсын 0-18 хүртэлх насны хүүхэд (цаашид “хүүхэд” гэх) эсхүл түүнийг төлөөлөх хууль ёсны эрх бүхий Монгол Улсын иргэнд олгоно.

1.3. Хүүхэд болон хүүхдийг төлөөлөн хүүхдийн мөнгө авах эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд) нь үйлчлүүлэх арилжааны банкиг өөрөө сонгох эрхтэй. Тухайн хүүхдэд хүүхдийн мөнгө олгох зөвхөн нэг банкиг сонгож, уг банкинд зөвхөн нэг данс нээлгэнэ.

1.4. Банк, банкны ажилтан нь үйлчлүүлэгчтэй харилцахдаа үл ялгаварлах, тэгш хандах зарчим баримтална.

Хоёр. Хүүхдийн мөнгө авах иргэний хүсэлтийг  
хүлээн авах, хянан шийдвэрлэх

2.1. Хүүхдийн эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд) эсхүл 16 насанд хүрсэн бол хүүхэд өөрийн биеэр хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргах эрхтэй.

2.2. Энэхүү журмын 2.1-д заасан иргэн сонгосон арилжааны банкинд биеэр очиж хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргана. Хүсэлт гаргахдаа дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж банкны ажилтанд өгнө:

2.2.1. хүүхдийг төлөөлөн хүүхдийн мөнгө авах эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд)-ийн иргэний цахим үнэмлэх;

2.2.2. хүүхдийн төрсний гэрчилгээ, хэрэв хүүхэд 16 насанд хүрсэн бол иргэний цахим үнэмлэх;

2.2.3. хүүхдэд Гэр бүлийн тухай хуулийн 63, 64 дүгээр зүйлд заасны дагуу асран хамгаалагч, харгалзан дэмжигч шаардлагатай бол мөн хуулийн 66.1-д заасны дагуу асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоосон тухай сум, дүүргийн Засаг даргын захирамж.

2.3. Банкны ажилтан нь энэхүү журмын 2.2.1-2.2.3-т заасан баримт бичгийг хүлээн авч өргөдлийн маягыг цахим хэлбэрээр бөглөн энэхүү журмын 2.1-д заасан иргэнээр баталгаажуулан гарын үсэг зуруулж, хүсэлтийг хүлээн авсан хугацааг өргөдөлд тодорхой бичнэ.

2.4. Энэхүү журмын 2.3-т заасан өргөдлийн маягт дахь мэдээллийн үнэн зөв байдлыг тухайн арилжааны банк бүрэн хариуцна.





2.5. Энэхүү журмын 2.3-т заасан өргөдлийн маягтыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.

2.6. Энэхүү журмын 2.1-д заасан иргэн нь хүүхдийн мөнгө авах дансыг хүүхэд тус бүрээр нээлгэх бөгөөд эдгээр дансыг нэгтгэн нэг дансаар хүүхдийн мөнгө авах хүсэлтэй бол тухайн банк нь уг иргэний дансанд холболт хийнэ.

2.7. Энэхүү журмын 2.3-т заасан мэдээллийг банкны ажилтан нь тухайн арилжааны банкны төвд, арилжааны банкны төв нь нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.8. Арилжааны банкны төв нь мэдээллийн санд шинээр нэмэгдсэн, дансны мэдээлэлд нь өөрчлөлт орсон хүүхдийн нэрсийн жагсаалтыг сар бүрийн 10-ны өдрийн дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.

2.9. Арилжааны банкуудаас ирүүлсэн нэрсийн жагсаалтын мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдал, нэгдмэл байдлыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

2.10. Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь шинээр төрсөн, нас барсан, харьяатаас гарсан зэрэг 0-18 хүртэлх насны хүүхдийн талаархи мэдээллийг сар бүрийн 5-ны дотор нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.11. Энэхүү журмын 2.10-т заасан мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүйгээс учирсан хохирлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцна.

2.12. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэхүү журмын 2.8-д заасан мэдээллийг Хүний хөгжил сангийн болон энэхүү журмын 2.10-т заасан мэдээлэлтэй тус тус тулган шалгаж, баталгаажуулан хүүхдийн мөнгө олгох нэрсийн жагсаалтыг тухайн сарын 15-ны дотор Монголбанк болон санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын Төрийн сангийн газар (цаашид “Төрийн сангийн газар” гэх)-т цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.

2.13. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн хүүхдийн мөнгө олгох нэрсийн жагсаалтын



мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдал, нэгдмэл байдлыг Монголбанк хариуцна.

2.14. Төрийн сангийн газар нь нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн мөнгө олгох хүүхдийн нэрсийн жагсаалтыг үндэслэн холбогдох санхүүжилтыг Монголбанк дахь хүүхдийн мөнгөний тусгай дансанд сар бүр энэхүү журмын 2.17-д заасан өдрөөс ажлын 3 хоногийн өмнө байршуулна.

2.15. Төрийн сангийн газрын хүүхдийн мөнгөнд олгосон санхүүжилт нь тухайн сард арилжааны банкуудад шилжүүлэх мөнгөнөөс илүү гарсан тохиолдолд үлдэгдэл мөнгийг Төрийн сангийн газрын дансанд буцаана.

2.16. Төрийн сангийн газрын хүүхдийн мөнгөнд олгосон санхүүжилт нь тухайн сард арилжааны банкуудад шилжүүлсэн мөнгөнөөс бага байгаа тохиолдолд дутагдсан санхүүжилтыг бүрэн гүйцээж санхүүжүүлэх үүргийг Төрийн сангийн газар хүлээнэ.

2.17. Монголбанк дахь хүүхдийн мөнгөний тусгай дансанд энэхүү журмын 2.14-т заасан хөрөнгө бүрэн байршсан тохиолдолд хүүхдийн мөнгө олгох нэрсийн жагсаалтыг үндэслэн Монголбанк арилжааны банкууд дахь тухайн хүүхэд бүрийн дансанд мөнгийг сар бүрийн 20-ны дотор бүрэн байршуулна. Хүүхдийн мөнгөний санхүүжилт бүрэн хийгдээгүй тохиолдолд Монголбанк хүүхдийн мөнгийг арилжааны банкинд шилжүүлэхгүй.

2.18. Иргэн хүүхдийн мөнгийг сар бүрийн 20-ны өдрөөс хойш өөрийн сонгосон арилжааны банкнаас авна.

2.19. Монголбанк нь хүүхдийн мөнгө олгож байгаа арилжааны банктэй сар бүр тооцоо нийлж, мөнгө олгосон нэрсийн жагсаалтыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад сар бүрийн 25-ны дотор цахим хэлбэрээр болон албан бичгээр хүргүүлнэ.

2.20. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хүүхдийн мөнгөний олголт, зарцуулсан хөрөнгийн мэдээг дараа сарын 4-ний дотор санхүү, төсвийн болон нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тус тус хүргүүлнэ.

Гурав. Хүүхдийн мөнгө олгох

3.1. Хүүхдийн мөнгийг иргэний хүсэлт гаргасан сараас нь тооцож сар бүр олгоно.

3.2. Иргэн хүүхдийн мөнгө авч байсан банкиг солих хүсэлтэй бол тухайн банкинд хандан мэдээллийн сангаас хасалт хийлгүүлж,



данс хаалгасан тухай лавлагааг дараагийн сонгосон арилжааны банкны ажилтанд хүүхдийн мөнгө авах хүсэлтийн хамт өгнө.

3.3. Иргэн засаг захиргааны нэг нэгжээс өөр нэгжид бүрмөсөн шилжин суурьшсан тохиолдолд шилжин очсон нутаг дэвсгэрийн банкны салбараас хүүхдийн мөнгийг үргэлжлүүлэн авна. Хэрэв тухайн банкны салбар нь шилжин очсон нутаг дэвсгэрт байхгүй бол энэхүү журмын 3.2-т заасны дагуу хүсэлтээ гаргана.

3.4. Бүтэн өнчин, эцэг эх, асран хамгаалагч нь тогтоогдоогүй зэрэг шалтгаанаар асрамжийн газарт асруулж байгаа хүүхдийн мөнгийг тухайн асрамжийн газар уг хүүхдийн нэр дээр хадгаламжийн данс нээлгэж банкинд хадгалуулна. Хадгаламжийн дэвтрийг тухайн асрамжийн газрын байрлаж байгаа аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага хадгалж, хүүхдийг 16 нас хүрч, иргэний үнэмлэх авсны дараа өөрт нь хүлээлгэн өгнө. Хэрэв хүүхэд нас барсан тохиолдолд түүний хадгаламжийн дэвтрийг өв залгамжлагчид нь хууль тогтоомжид заасны дагуу хүлээлгэн өгнө.

3.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар түүний харьяа анги, байгууллагад ял эдэлж байгаа болон цагдан хоригдож байгаа хүүхдийн мөнгийг тухайн хүүхдийн нэр дээр хадгаламжийн данс нээлгэж банкинд хадгалуулна. Хадгаламжийн дэвтрийг тухайн хорих ангийн байрлаж байгаа аймаг, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага хадгалж, хүүхдийг суллагдсаны дараа өөрт нь хүлээлгэн өгнө. Хэрэв хүүхэд 16 насанд хүрээгүй бол эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд)-д, нас барсан бол өв залгамжлагчид нь хууль тогтоомжид заасны дагуу мөнгийг хүлээлгэн өгнө.

3.6. Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэний хүүхдийн мөнгийг төлөөлөн авах иргэний өргөдөл, хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын итгэмжлэл, тодорхойлолтыг үндэслэн итгэмжлэгдсэн этгээдэд нь олгоно.

3.7. Харьяатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчиж хоёрдмол харьяалалтай болсон иргэний хүүхдэд хүүхдийн мөнгө олгохгүй.

3.8. Хүүхэд шинээр төрсөн, үрчлэгдсэн, нас барсан зэргээр тухайн гэр бүлд амьдарч байгаа хүүхдийн тоо өөрчлөгдсөн бол эх (эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, итгэмжлэгдсэн этгээд) нь энэ тухай сонгосон арилжааны банк болон тухайн орон нутгийн улсын бүртгэлийн байгууллага, ажилтанд бичгээр мэдэгдэнэ.



## Дөрөв. Хүүхдийн мөнгө олгохыг зогсоох

4.1. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь тохиолдолд хүүхдийн мөнгө олгохыг зогсоох шийдвэр гаргана:

- 4.1.1. хүүхэд 18 нас хүрсэн;
- 4.1.2. хүүхэд нас барсан;
- 4.1.3. Монгол Улсын харьяатаас гарсан.

4.2. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага дараахь тохиолдолд хүүхдийн мөнгө олгохыг түр зогсоох шийдвэр гаргана:

4.2.1. хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэл өгөх зэргээр хүүхдийн мөнгө авсан нь тогтоогдсон;

4.2.2. хүүхдийн мөнгө авахаар нэг хүүхдийн нэр дээр давхар данс нээлгэсэн.

4.3. Энэхүү журмын 4.2-т заасны дагуу түр зогсоосон тэтгэмжийг алдааг залруулсны дараа хүүхдийн мөнгийг үргэлжлүүлэн олгох бөгөөд түр зогсоосон хугацааны хүүхдийн мөнгийг нөхөн олгохгүй.

## Тав. Бусад

5.1. Иргэн энэхүү журмын 2.2-т заасан баримт бичгийг хуурамчаар үйлдэж хүүхдийн мөнгө авсан эсхүл 3.8-д заасан өөрчлөлтийг мэдэгдээгүй бол илүү авсан хугацааных нь хүүхдийн мөнгийг эхний удаа нөхөн төлүүлэх буюу дараа сарынх нь хүүхдийн мөнгөнөөс суутгана.

5.2. Энэхүү журмын 5.1-д заасан суутгалыг нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэдэгдлийг үндэслэн арилжааны банк суутгаж, холбогдох дансанд төвлөрүүлэн энэ тухай мэдээллийг энэхүү журмын 2.8-д заасан жагсаалтын хамт хүргүүлнэ.

5.3. Нийгмийн халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон банкны ажилтны гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлж, хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

### Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiiin\_medecelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 0.75

Индекс: 14003